



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/302

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн “Сурах бичгийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 98 дугаар тогтоолын 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.
2. Энэхүү журмыг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Нансалмаа/-т тус тус даалгасугай.
4. Боловсролын салбарын мэдээллийн систем, Анги удирдсан багшийн дэвтрийн холбогдох мэдээллүүдэд төлбөртэй ашиглуулах сурах бичгийн талаар тусгаж, мэдээллийн нэгдмэл байдлыг хангахыг Төрийн захиргааны удирдлагын газар /О.Хуягцогт/, Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/-т тус тус үүрэг болгосугай.
5. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 47 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сурагчдад сурах бичгийг түрээсээр ашиглуулах түр журам”-г хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Е.БААТАРБИЛЭГ

300907

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын сайдын 2019 оны 05 дүгээр  
сарын 14-ний өдрийн 4/302 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад  
сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ерөнхий боловсролын сургууль /цаашид “сургууль” гэх/-ийн дунд, ахлах ангийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээтэй холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Төрөөс сурах бичгээр үнэ төлбөргүй хангах зорилтот бүлгийн суралцагчдад энэ журмын зохицуулалт хамаарахгүй.

1.3. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.  
Үүнд:

1.3.1. “Сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээ” гэж дунд, ахлах ангийн суралцагчдад сургуулийн номын сангаар дамжуулан тухайн хичээлийн жилд сурах бичгийг тодорхой хэмжээний төлбөртэй, буцаан авах нөхцөлтэй хэрэглүүлэх үйл явц;

1.3.2. “Төлбөртэй ашиглуулах сурах бичиг” гэж дунд, ахлах ангийн сургалтад ашиглагдаж байгаа үндсэн сурах бичиг;

1.3.3. “Сурах бичиг ашиглах төлбөр” гэж суралцагч суралцах ангийнхаа бүх /багц/ сурах бичгийг хичээлийн жилийн турш ашиглахтай холбогдох төлбөр;

1.3.4. “Төлбөртэй ашиглуулах сурах бичгийн ашиглалтын хугацаа” гэж сурах бичиг хэрэглээнд орсноос хойш элэгдэж, шинээр солих шаардлагатай болох хүртэлх хугацааг.

### Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хэмжээнд нэвтрүүлж, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1 Төлбөртэй ашиглуулах сурах бичиг /цаашид “сурах бичиг” гэх/-ийг хэвлэн нийлүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, аймгийн боловсролын газар, нийслэлийн сургууль бүрт хүргүүлнэ.

2.1.2 Холбогдох заавар, зөвлөмж боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хүргүүлнэ.

2.1.3 Сурах бичгийн захиалгад үндэслэн нөхөн хангалт хийх ажлыг жил бүр зохион байгуулна.

2.1.4 Сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

2.2. Аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг орон нутгийн хэмжээнд нэвтрүүлж, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1 Энэхүү журмын 2.1.1-д заасны дагуу хэвлэн хүргэгдэж ирсэн сурах бичгийг аймгийн боловсролын газар хүлээн авч, сум, тосгоны сургуульд хүргэх ажлыг сургуулийн захиргаатай хамтран зохион байгуулна.

2.2.2 Энэхүү журмын 2.1.1-д заасан дагуу нийслэлийн сургууль тус бүрт сурах бичиг хүргэх ажилд дүүргийн боловсролын хэлтэс дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана.

2.2.3 Шаардлагатай тохиолдолд сургууль хооронд сурах бичиг шилжүүлэх зохицуулалт хийнэ.

2.3. Ерөнхий боловсролын сургууль нь сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг сургуулийн хэмжээнд нэвтрүүлж, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.3.1 Сурах бичгийг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг хүлээн авч, акт үйлдэн эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэнэ.

2.3.2 Сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журмыг багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулах, төлбөр төлөх заавар өгөх ажлыг сургуулийн захирал хариуцан зохион байгуулна.

2.3.3 Сурах бичгийг ангилж, төлбөрийн баримтыг үндэслэн анги удирдсан багш нарт хүлээлгэн өгч бүртгэл тооцоо хөтлөх ажлыг сургуулийн номын санч хариуцан зохион байгуулна.

2.3.4 Суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай гэрээ байгуулж, сурах бичгийг суралцагчдад олгох, буцаан авах үйл ажиллагааг анги удирдсан багш нь ангийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран зохион байгуулна.

2.3.5. Багш нар нь сурах бичгийг цэвэр нямбай, гамтай хэрэглэх талаар суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад заавар, зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллана.

### **Гурав. Сурах бичиг ашиглуулах үйлчилгээний төлбөр**

3.1. Сурах бичиг ашиглуулах үйлчилгээний төлбөр /цаашид “төлбөр” гэх/-ийн хэмжээг энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу анги тус бүрээр, сурах бичиг ашиглагдсан хугацаанаас хамаарсан ялгаатай тогтоож, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар баталгаажуулна.

3.2. Төлбөрийг төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн суралцагч сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансанд, төрийн бус өмчийн сургуулийн суралцагч тухайн байгууллагын дансанд тус тус тушаана.

3.3. Төлбөр төлөгч этгээд төлбөрийн баримтын гүйлгээний утга хэсэгт сургууль, анги, бүлэг, суралцагчийн овог, нэрийг тодорхой бичнэ.

3.4. Сургууль нь энэхүү журмын 3.4-т заасан дансанд төвлөрсөн төлбөрийг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төв төрийн сан дахь "СБТТогтолцоо-Эргэлтийн сан 100900015403" дугаар дансанд шилжүүлнэ.

3.5. Сургууль нь төлбөрийн баримтын гүйлгээний утга хэсэгт аймаг, сум, дүүрэг, сургуулийн нэрийг тодорхой бичнэ.

3.6 Төлбөрийг хугацаанд нь холбогдох дансанд шилжүүлэх, өр авлага үүсгэхгүй байхад сургуулийн захирал хяналт тавина.

3.7. Төлбөрийг сургууль бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

3.8. Сурах бичиг ашиглуулсны төлбөрөөр бий болсон эх үүсвэрийг төлбөртэй ашиглуулах сурах бичгийг нөхөн хангах болон хяналт тавих зардал, сум, тосгонд сурах бичиг хүргэхтэй холбоотой зардлын зарим хэсэгт зарцуулна.

3.9. Энэхүү журмын 3.9-д заасан зардлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар жил бүр батална.

#### **Дөрөв. Захиалга, тайлан, мэдээ**

4.1. Сургууль нь сурах бичиг төлбөртэй ашиглуулсантай холбоотой тайлан, мэдээг энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан Маягт 1-ийн дагуу жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор, сурах бичгийн нөхөн хангалт хийх захиалгыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэст ирүүлнэ.

4.2. Аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь сургуулиудаас ирүүлсэн тайланг нэгтгэн энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан Маягт 2-ын дагуу жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор, сурах бичгийн нөхөн хангалт хийх захиалгыг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

#### **Тав. Бусад**

5.1. Төлбөртэй ашиглуулах сурах бичгийг үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болгосон тохиолдолд буруутай этгээд тухайн сурах бичгийн үнийг энэхүү журмын 3.4-д заасан дансанд тушаана.

5.2. Төлбөртэй ашиглуулах сурах бичиг нь бусад сурах бичгээс ялгагдах тэмдэглэгээтэй байна.

5.3. Энэхүү журмыг зөрчсөн албан хаагчийн үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

Сурах бичиг ашиглуулах үйлчилгээний төлбөрийн хэмжээ  
тогтоох аргачлал

1. Сурах бичиг ашиглуулах үйлчилгээний төлбөр /цаашид “төлбөр” гэх/-ийн хэмжээг тооцохдоо гурваас дөрвөн жилийн дараа төлбөртэй ашиглуулах хэрэгцээт бүх сурах бичгийг дахин худалдан авахад шаардагдах зардлын эх үүсвэр хуримтлуулсан байх ёстойг харгалзана. Төлбөрийн хэмжээ сурах бичиг ашиглагдсан жилээс хамаарч жил бүр буурсан байна.

2. Дараах хүчин зүйлсийг тооцон төлбөрийн хэмжээг тодорхойлно.

Сурах бичгийн багц дахь номын тоо ...

№	Тооцоололд хамаарах хүчин зүйлс	Коэффициент
a	Сурах бичгийн багцын үнэ	x
b	4 жилийн элэгдэл /12%/	1.12
c	4 жилийн инфляци /32%/	1.32
d	Суралцагчийн тооны 4 жилийн өсөлт /4%/	1.04
e	Сурах бичгийн ашиглалтын хугацаа	4 жил
f	Төлбөрийн хуримтлалын хувь /98%/	0.98

3. Төлбөрийн дунджийг тооцоолох томъёо:

$$\text{Төлбөрийн дундаж} = \frac{\text{Сурах бичгийн багцын үнэ (a) * элэгдлийн хувь (b) * инфляци (c) * суралцагчийн тооны өсөлт (d)}}{\text{Сурах бичгийн ашиглалтын хугацаа (e) * төлбөрийн хуримтлалын хувь (f)}}$$

4. Сурах бичиг ашиглагдсан хугацаанаас хамааруулж төлбөрийг тооцохдоо (a) шинэ сурах бичгийн хувьд төлбөрийн дунджийг 1,06 гэсэн, (b) 2 дахь жилдээ ашиглагдах сурах бичгийн хувьд төлбөрийн дунджийг 1,03 гэсэн, (c) 3 дахь жилдээ ашиглагдах сурах бичгийн хувьд төлбөрийн дунджийг 0,97 гэсэн, (d) 4 дэх жилдээ ашиглагдах сурах бичгийн хувьд төлбөрийн дунджийг 0,94 гэсэн итгэлцүүрээр тус тус үржүүлнэ.

---oOo---

